




МАЛ ТООЛЛОГО-2019



2020 он

ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж, энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2020 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1244 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/401 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлын хэсэг, тэдний ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ - 5 хонь
- 1 адуу - 7 хонь
- 1 үхэр - 6 хонь
- 1 хонь - 1 хонь
- 1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ - Өнгөрсөн жилийн төл 2, 3 настай
- Адуу - Өнгөрсөн жилийн төл 2 настай
- Үхэр - Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн

мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга - 10 гүү
- 1 Бух - 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Малын зүй бусын хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түмэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | |
|-------------------------|--|
| • Хадлан өвс | 0.45 |
| • Таримал тэжээл | 0.35 |
| • Даршны ургамал | 0.25 |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0 |
| • Үр тарианы хаягдал | 0.9 |
| • Лай | 0.4 |
| • Сүрэл | 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО: 2019 оны мал тооллогоор хувийн малтай 742 өрх, үүнээс 492 өрх мал аж ахуй эрхэлж байна. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад:

Хүснэгт 1. Малтай, малчин өрх, хороогоор


		2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт мал бүхий өрх	1-р хороо	163	150	166	167
	2-р хороо	78	81	80	89
	3-р хороо	168	166	155	152
	4-р хороо	177	170	186	170
	5-р хороо	138	145	144	164
Дүүргийн дүн		724	728	731	742
Үүнээс: Малчин өрх	1-р хороо	77	89	95	93
	2-р хороо	70	75	80	87
	3-р хороо	76	57	93	71
	4-р хороо	99	130	174	144
	5-р хороо	77	86	117	97
Дүүргийн дүн		399	437	559	492

2019 оны байдлаар хувийн малтай 742 өрх байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11 (1.5%) өрхөөр өссөн байна. Мөн мал аж ахуй эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 492 байгаа нь өнгөрсөн оноос 67 (12.0%) өрхөөр буурсан байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрхийн ам бүл, малчдын тоо

		2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт мал бүхий өрх		724	712	728	742
Түүний ам бүл		2 433	2 389	2 513	2 403
Үүнээс: Малчин өрх		399	437	559	492
Түүний ам бүл		1 336	1 465	1 911	1 547
Малчдын тоо		672	649	797	687
16-34 насны		126	152	194	151
35-аас тэтгэвэрт гарах насны		405	335	420	361
Тэтгэврийн насны		141	162	183	175
Нийт малчдаас эмэгтэй		302	277	323	281
Насны бүтэц					
16-34 насны		18.8	23.4	24.3	22.0
35-аас тэтгэвэрт гарах насны		60.3	51.6	52.7	52.5
Тэтгэврийн насны		21.0	25.0	23.0	25.5

Зураг 1. Малчдын тоо /насны бүлгээр/



Мал аж ахуйн салбарт 687 малчин ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 22.0 хувь нь 16-34 насны, 52.5 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 25.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 281 нь буюу 40.9 хувь нь эмэгтэй малчид байна.

МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Зураг 2. Ахуй соёлын үзүүлэлт



Нийт малчин өрхийн:

585 өрх буюу 118.9 хувь нь байгаа нь 93 өрх давхардсан цахилгааны эх үүсвэртэй

389 өрх буюу 79.1 хувь нь зурагтай

573 өрх буюу 116.5 хувь нь байгаа нь 81 өрх 2-с дээш сансарын антентай

179 өрх буюу 36.4 хувь нь радиотой

212 өрх буюу 43.1 хувь нь оёдлын машинтай


176 өрх буюу 35.8 хувь нь хөлдөөгчтэй

МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн тоо 200183 толгойд хүрч, өнгөрсөн оноос 15846 толгой малаар буюу 8.6 хувиар өссөн.

Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018	
					зөрүү	хувь
Тэмээ	209	224	203	210	7	3.4
Адуу	14 043	13 391	14 652	16 066	1 414	9.7
Үхэр	14 198	14 563	15 866	16 823	957	6.0
Хонь	91 271	88 526	92 757	99 691	6 934	7.5
Ямаа	59 053	55 345	60 859	67 393	6 534	10.7
НИЙТ МАЛ	178 774	172 049	184 337	200 183	15 846	8.6

Зураг 3. Малын тоо, оноор



Энэ жилийн тооллогоор тэмээн сүрэг 7 толгой буюу 3.4 хувиар өсч, адуун сүрэг 1414 толгой буюу 9.7 хувиар, үхэр сүрэг 957 толгой буюу 6.0 хувиар, хонин сүрэг 6934 толгой буюу 7.5 хувиар, ямаан сүрэг 6534 толгой буюу 10.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Малын орлого, зарлага, төрлөөр

	Орлого					Зарлага			
	Худалдаж авсан,	шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Зах зээлд борлуулсан	шилжүүлсэн	Алдсан олодохгүй байсан мал	Алдсан, хулгайлагдсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Тэмээ	2	10	36	39	-	-	-	2	-
Адуу	987	419	3 589	2 383	557	42	57	474	152
Үхэр	988	763	4 847	3 789	717	5	19	992	129
Хонь	5 702	4 492	31 511	23 100	5 263	6	66	5 518	830
Ямаа	5 083	3 021	19 111	13 352	3 068	-	232	3 243	786
Дүн	12 762	8 705	59 094	42 663	9 605	53	374	10 229	1 897

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төлөөр 59094 толгой, худалдаж авсан болон шилжиж ирсэн малаар 21467 толгой мал тус тус нэмэгдэж, харин 42663 толгой мал зах зээлд борлуулагдаж, 9605 толгой мал шилжүүлж, 374 толгой мал алдаж, 10229 толгой мал хүнсэнд хэрэглэж, 1897 толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Хүснэгт 5. Малын тооны өсөлтөнд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018	
					зөрүү	хувь
Бэлэн тоологдсон төл	51 107	44 960	55 968	59 094	3 126	5.6
Том малын зүй бусын хорогдол	882	3 273	2 589	1 897	-692	-26.7
Хээлтэгч малын тоо	82 523	80 759	80 667	92 364	11 697	14.5
Хээл хаясан хээлтэгч	1 221	2 007	755	6 232	5 477	8.3'
Сувайрсан хээлтэгч	5 059	12 191	7 402	8 882	1 480	20.0

‘дахин өссөн

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлнээр тоологдсон төл өнгөрсөн оноос 3126 (5.6%) төлөөр нэмэгдэж, том малын зүй бус хорогдол өнгөрсөн оноос 692 (26.7%) толгойгоор буурч, хээлтэгч малын тоо 11697 (14.5%) тус тус өссөн нь энэ жилийн малын тооны өсөлтөнд нөлөөлсөн байна.


МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ: 2019 оны байдлаар нийт мал сүргийн 83.5 хувийг бог мал, 16.5 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулвал:

Хүснэгт 6. Нийт малд эзлэх хувийн жин, төрлөөр

	2016 он	2017 он	2018 он	2019 он
НИЙТ МАЛ	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.1	0.1	0.1	0.1
Адуу	7.9	7.8	7.9	8.0
Үхэр	7.9	8.5	8.6	8.4
Хонь	51.1	51.5	50.3	49.8
Ямаа	33.0	32.2	33.0	33.7

Үүнээс харахад тэмээ, адуу, үхэр сүргийн эзлэх хувь сүүлийн 4 жил харьцангуй тогтвортой байна. Бог малын хувьд хонин сүргийн эзлэх хувь буурч ямаан сүргийн эзлэх хувь өссөн байна. Бог малын 59.7 хувийг хонин сүрэг, 40.3 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Зураг 4. Бог малын бүтэц



Энэ жил ямаан сүрэг 67393 толгойд хүрч өмнөх оноос 6534 толгой буюу 10.7 хувиар өссөн байна. Ямаан сүргийн тоо толгой болон бог малд эзлэх хувь сүүлийн 4 жил өсч байгаа нь бэлчээрийн даац болон сүргийн бүтцэд сөргөөр нөлөөлж байна.


МАЛЫН ТОО ХОРООГООР: Энэ жилийн тооллогоор 3 хорооны мал 1228 толгой буюу 2.6 хувиар буурч, бусад хороодын мал 6.2-22.1 хувиар өссөн байна. Доорх хүснэгтэнд хороодын 2019 онд тоологдсон малыг өмнөх онтой харьцуулан өсөлт бууралтыг тоо болон хувиар харуулж байна.

Хүснэгт 7. Малын тоо, хороогоор

		2016 он	2017 он	2018 он	2019 он	өсөлт, бууралт	
						тоо	хувь
хороогоор	1-р хороо	52 207	42 856	45 357	50 725	5 368	11.8
	2-р хороо	11 838	11 964	11 737	13 821	2 084	17.8
	3-р хороо	43 939	43 683	47 457	46 229	-1 228	-2.6
	4-р хороо	45 843	47 027	50 246	53 339	3 093	6.2
	5-р хороо	24 947	26 519	29 540	36 069	6 529	22.1
Дүүргийн дүн		178 774	172 049	184 337	200 183	15 846	8.6

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО: Мал тооллогоор амины малын тоо 194120 толгойд хүрч нийт малын 96.9 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оноос 15506 толгой малаар буюу 8.7 хувиар өссөн байна.

Зураг 5. Амины мал



Хүснэгт 8. Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2016	724	172 982	209	13 822	13 900	87 135	57 916	239
2017	712	165 442	224	13 076	14 110	84 506	53 526	232
2018	728	178 604	203	14 293	15 421	89 090	59 597	245
2019	742	194 120	210	15 718	16 310	95 801	66 081	262

2019 оны байдлаар амины малын 34.0 хувийг ямаа, 49.4 хувийг хонь, 8.1 хувийг адуу, 8.4 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээ эзэлж байна. Мөн энэ жил 1 өрх дунджаар 262 толгой малтай болсон нь өнгөрсөн оноос 17 толгой малаар буюу 6.9 хувиар өссөн байна.



Амины малтай 1 өрхөд дунджаар тэмээ 0.3 толгой, адуу 21.2 толгой, үхэр 22.0 толгой, хонь 129.1 толгой, ямаа 89.1 толгой ногдож байна.

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ: Нийт малтай өрхийн 41.8 хувь буюу 310 өрх 100 хүртэлх толгой малтай, 20.1 хувь буюу 149 өрх 101-200 толгой малтай, 22.4 хувь буюу 166 өрх 201-500 толгой малтай, 10.5 хувь буюу 78 өрх 501-999 толгой малтай байна.

Хүснэгт 9. Малтай өрхийн малын бүлэглэлт

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь	
	2018 он	2019 он	2018 он	2019 он
0-100 малтай	328	310	45.1	41.8
101-200 малтай	128	149	17.6	20.1
201-500 малтай	176	166	24.2	22.4
501-999 малтай	71	78	9.8	10.5
1000-1499 малтай	22	29	3.0	3.9
1500-2000 малтай	3	4	0.4	0.5
2000 дээш малтай	-	6	-	0.8
Бүгд	728	742	100.0	100.0

1000 ба түүнээс дээш толгой малтай өрх 39 байгаа нь нийт өрхийн 5.3 хувийг эзэлж байна. Үүний 29 өрх 1000-1499 толгой мал, 4 өрх 1500-2000 толгой мал тоолуулсан байна. Энэ жил 2000 дээш толгой малтай 6 өрх тоологдсон байна.



Амины малтай нэг өрх дунджаар 3.2 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд 80.8 толгой мал ногдож байна. Энэ нь өнгөрсөн оноос 1.1 толгой малаар өссөн байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛ: 2019 оны эцэст 92364 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 7899 толгойгоор буюу 9.4 хувиар өссөн ба ингэ 52.5 хувиар, гүү 8.8 хувиар, үнээ 6 хувиар, эм хонь 3.2 хувиар, эм ямаа 4.2 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 10. Хээлтэгч мал, төрлөөр

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018	
					тоо	хувь
Ингэ	73	74	59	90	31	52.5
Гүү	4 546	4 586	5 116	5 567	451	8.8
Үнээ	5 734	5 912	6 582	6 974	392	6.0
Эм хонь	43 929	42 832	44 192	47 880	3 688	8.3
Эм ямаа	28 241	27 355	28 516	31 853	3 337	11.7
Бүгд	82 523	80 759	84 465	92 364	7 899	9.4

Хээлтэгч мал нийт малын 46.1 хувийг эзэлж байгаа бөгөөд

- тэмээн сүргийн – 42.9 хувь
- адуун сүргийн – 34.7 хувь
- үхэр сүргийн – 41.5 хувь
- хонин сүргийн – 48.0 хувь
- ямаан сүргийн – 47.3 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 6. Хээлтэгч малын тоо



БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ: Энэ оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 59094 толгой болж өнгөрсөн оноос 3126 толгойгоор буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 11. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018	
					тоо	хувь
Ботго	25	25	33	36	3	9.1
Унага	2 600	2 214	3 147	3 589	442	14.0
Тугал	3 970	3 853	4 421	4 847	426	9.6
Хурга	27 973	25 017	30 078	31 511	1 433	4.8
Ишиг	16 539	13 851	18 289	19 111	822	4.5
Бүгд	51 107	44 960	55 968	59 094	3 126	5.6

Өнгөрсөн оны тооллогоор 84465 толгой хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд

- хээлтэй малын орлогоор 5554 толгой мал нэмэгдэж
- доод наснаас төллөсөн хээлтэгч 2117
- хээлтэй мал 7912 толгойг зарлагдаж
- хээл хаясан 6232 толгой мал
- сувайрсан хээлтэгч 8882 толгой мал тус тус хасагдаж 69107 толгой хээлтэгч төллөсөн нь нийт төллөх насны хээлтэгчийн 81.8 хувь байна.

Хүснэгт 12. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж	
					авсан шилжиж ирсэн	Худалдсан шилжүүлсэн
Ботго	41	41	5	36	-	-
Унага	4 232	4 232	45	4 187	47	645
Тугал	5 433	5 433	61	5 372	80	605
Хурга	36 380	36 392	438	35 954	924	5367
Ишиг	23 021	23 024	395	22 629	628	4146
Бүгд	69 107	69 122	944	68 178	1 679	10 763

2019 онд 69122 толгой төл хүлээн авсан бөгөөд 944 толгой төл мал хорогдож төл бойжилт 98.6 хувьтай байна.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ: 2019 оны тооллогоор 1897 толгой том мал хорогдсон бөгөөд энэ нь оны эхний малын 1.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өнгөрсөн оноос 692 толгойгоор буюу 26.7 хувиар буурсан байна. Нийт хорогдсон том малын 8.0 хувийг адуу, 6.8 хувийг үхэр, 43.8 хувийг хонь, 41.4 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 13. Том малын зүй бусын хорогдол, төрлөөр

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018	
					зөрүү	дахин
Тэмээ	-	-	-	-	-	-
Адуу	52	343	223	152	-71	-31.8
Үхэр	155	343	389	129	-260	-66.8
Хонь	375	1 349	1 026	830	-196	-19.1
Ямаа	300	1 238	951	786	-165	-17.4
Бүгд	882	3 273	2 589	1 897	-692	-26.7

Энэ онд хорогдсон нийт малын 238 (12.5%) толгой мал гэнэтийн аюулаар, 70 (3.7%) толгой мал өвчнөөр, 148 (7.8%) толгой мал зэрлэг амьтанд бариулж, 1441 (76.0%) толгой мал бусад шалтгаанаар хорогдсон байна.

Хүснэгт 14. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2016 он	2017 он	2018 он	2019 он
Тэмээ	-	-	-	-
Адуу	0.4	2.4	1.7	1.0
Үхэр	1.3	2.4	2.7	0.8
Хонь	0.5	1.5	1.2	0.9
Ямаа	0.6	2.1	1.7	1.3
БҮГД	0.6	1.8	1.5	1.0

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО: 2019 онд 1493 хээлтүүлэгч мал тоологдож өмнөх оноос 28 толгойгоор буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

	Хээлтүүлэгчийн тоо	Үржлийн норм	2016 он	2017 он	2018 он	2019 он
Ингэ	2	20	37	25	20	45
Гүү	552	10	9	9	9	10
Үнээ	184	25	33	32	34	38
Эм хонь	444	50	106	110	111	108
Эм ямаа	311	60	93	98	93	102

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо адуун сүргээс бусад сүргийн хувьд алдагдаж байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-60 хээлтэгч ногдох ёстой атал тооллогоор хонь ямаан сүргийн хувьд 108 эм хонь, 102 эм ямаанд 1 хээлтүүлэгч ногдож байгаа нь үржлийн нормоос 1.5-2 дахин их байна.

БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ: Манай дүүрэг 62020 га газар нутагтай 2019 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 39106.9 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байна. Үүнээс бэлчээрийн талбай 38327.5 га болсон байна. 2019 оны тооллогоор тоологдсон малын тоо хонин толгойд шилжүүлснээр 374795 болсон нь өнгөрсөн оноос 28490 толгой буюу 8.2 хувиар өссөн байна.

Зураг 7. Нутаг дэвсгэрийн хэмжээ



Хүснэгт 16. Бэлчээрийн даац

	2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт малын тоо /хонин толгой/	328 953	320 572	346 305	374 795
Бэлчээрийн талбай	39 267.7	38 710.9	38 06.1	38 327.5
100 га-д ногдох малын тоо	837.7	828.1	894.7	977.9

Дүүргийн 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 977 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 83.2 толгой малаар буюу 9.3 хувиар өссөн байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2020 оны 2 дугаар сарын 17